

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын "Гэрэлтэй" өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/53/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www. Shinjlenmagadlahui. ezsh.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjlenmagadlahui.audit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	21
5.2 Албан шаардлага	21
5.3 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ГЭРЭЛТЭЙ” ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Л.НЯМСҮРЭН ТАНАА

Авдс. Дд. Дд № *102*

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дархан Уул аймгийн Дархан сумын “Гэрэлтэй” өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өрхийн эрүүл мэндийн төв нь нэг иргэнээр тооцсон төлбрийн аргаар санхүүждэг. Тайлант онд нэг иргэнээр тооцсон санхүүжилт 598,851.8 мянган төгрөг, дөрвөн тусламж үйлчилгээний 155,894.6 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/212 тоот тушаалаар батлагдсан өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрмийг мөрдлөг болгон ажилладаг. Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх өрхийн эрүүл мэндийн төвийн баг нь нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд байна гэж тус үлгэрчилсэн дүрэмд заасан байна. Нөхөрлөлийн хэлбэрээр байгуулагдсан төв нь дараах зохион байгуулалттай байна. Үүнд:

4525020143

- Тухайн төвд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтний 70-аас доошгүй хувь нь нөхөрлөлийн гишүүн байна.
- Төвийн удирдлага нь нөхөрлөлийн бүх гишүүдийн хурал байна гэж заасан ба төвийн төсөв хөрөнгө хэрхэн зарцуулах талаар мөн нөхөрлөлийн гишүүдийн хурлаар шийдвэрлэдэг байна.
- Монгол Улсын засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолыг жишиг болгон өрхийн эрүүл мэндийн төвийн ажилчдын цалингийн хэмжээг нөхөрлөлийн хурлын шийдвэрт үндэслэн 20 хувиар нэмэгдүүлснээр цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 16 хувиар нэмэгдсэн.

Дархан сумын “Гэрэлтэй” өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 74.5 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ, 1.0 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал тус тус эзэлж байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлага хүлээнэ.

Дархан Уул аймгийн Дархан сумын “Гэрэлтэй” өрхийн эрүүл мэндийн төв нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 1 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 95.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/


Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>291,516,568.04</u>	<u>264,793,273.09</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	153,891,546.32	122,179,863.28
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	153,891,546.32	122,179,863.28
3121	Төгрөг	153,891,546.32	122,179,863.28
31211	Харилцах данс	153,891,546.32	122,179,863.28
33	АВЛАГА	33,477,420.00	58,735,300.23
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	33,477,420.00	58,735,300.23
35	БАРАА МАТЕРИАЛ	104,147,601.72	83,878,109.58
351	Түүхий эд материал	74,993,493.99	47,020,730.20
35110	Тусгай зориулалттай материал	26,219,614.00	20,393,724.00
35130	Эм боох материал	48,773,879.99	26,627,006.20
354	Хангамжийн материал	29,154,107.73	36,857,379.38
35410	Бичиг хэргийн материал	894,930.00	1,210,500.00
35420	Аж ахуйн материал	28,259,177.73	35,399,879.38
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>419,988,714.10</u>	<u>434,311,157.61</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	419,988,714.10	434,311,157.61
392	Биет хөрөнгө	374,904,713.90	389,227,157.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	179,562,348.00	179,562,348.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(21,077,234.93)	(26,044,348.61)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	24,900,000.00	24,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,224,999.94)	(10,374,999.90)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	299,613,781.19	365,178,321.19
39206	Хуримтлагдсан элэгдэл	(129,921,131.77)	(172,002,444.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,672,680.00	33,304,805.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,202,021.65)	(14,694,179.74)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,774,927.00	11,764,927.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,193,634.00)	(2,367,270.76)
393	Биет бус хөрөнгө	45,084,000.20	45,084,000.00
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,299.80)	(1,124,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	45,084,000.00	45,084,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>711,505,282.14</u>	<u>699,104,430.70</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	711,505,282.14	699,104,430.70
51	Засгийн газрын хувь оролцоо	711,505,282.14	699,104,430.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	182,225,247.40	182,225,247.40
51101	Өмч: - төрийн	182,225,247.40	182,225,247.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	730,981,114.68	878,485,738.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,333,733.80	98,481,375.98
120	Нийтлэг татварын бус орлого	41,333,733.80	98,481,375.98
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	37,264,747.20	76,425,265.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	4,068,986.60	22,056,110.58
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	689,647,380.88	780,004,362.92
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	689,647,380.88	780,004,362.92
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	689,647,380.88	780,004,362.92
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	762,998,522.20	890,886,590.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	762,998,522.20	890,886,590.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	751,067,741.20	879,891,617.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	488,705,300.00	562,563,259.00
210101	Үндсэн цалин	441,041,300.00	358,779,253.00
210102	Нэмэгдэл	-	63,312,806.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	58,166,000.00
210104	Урамшуулал	47,664,000.00	82,305,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,750,894.24	74,451,175.73
210201	Тэтгэврийн даатгал	44,204,686.36	52,441,727.05
210202	Тэтгэмжийн даатгал	4,689,721.88	6,028,232.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,473,272.15	2,832,615.42
210204	Ажилгүйдлийн даатгал	941,583.87	2,629,719.26
210205	Эрүүл мэндийн даатгал	9,441,629.98	10,518,881.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,241,998.00	6,659,223.00
210301	Гэрэл, цахилгаан	1,742,886.00	1,605,260.00
210302	Түлш, халаалт	4,524,639.00	4,491,921.00
210303	Цэвэр, бохир ус	974,473.00	562,042.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,424,778.03	44,020,578.41
210401	Бичиг хэрэг	7,009,795.00	7,102,284.00
210402	Тээвэр, шатахуун	2,793,000.00	3,496,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,796,800.00	1,557,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	440,000.00	1,015,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35,036,977.00	30,849,134.41
2105	Нормативт зардал	56,318,707.32	85,911,942.31
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56,318,707.32	84,454,742.31
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,457,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,600,000.00	8,300,000.00
210604	Урсгал засвар	4,600,000.00	8,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,097,600.00	5,267,400.00
210702	Дотоод албан томилолт	1,097,600.00	5,267,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,436,207.00	19,084,817.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,708,270.00	17,509,780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,837.00	54,837.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	450,000.00
210807	Газрын төлбөр	1,698,000.00	95,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,492,256.61	73,633,221.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,173,577.00	2,130,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,553,679.61	71,502,821.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,930,781.00	10,994,973.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,930,781.00	10,994,973.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,191,346.00	834,233.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,739,435.00	10,160,740.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(32,017,407.52)	(12,400,851.44)



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>656,169,960.88</u>	<u>754,746,482.69</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	656,169,960.88	754,746,482.69
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	656,169,960.88	754,746,482.69
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	656,169,960.88	754,746,482.69
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>692,279,945.24</u>	<u>777,058,165.73</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	692,279,945.24	777,058,165.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	680,349,164.24	763,963,192.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	488,705,300.00	562,563,259.00
210101	Үндсэн цалин	423,664,622.00	562,563,259.00
210104	Урамшуулал	65,040,678.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,750,894.24	74,451,175.73
210201	Тэтгэврийн даатгал	44,204,686.36	54,768,119.03
210202	Тэтгэмжийн даатгал	4,689,721.88	3,172,968.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,473,272.15	1,497,384.07
210204	Ажилгүйдлийн даатгал	941,583.87	1,385,435.58
210205	Эрүүл мэндийн даатгал	9,441,629.98	13,627,268.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,241,998.00	6,659,223.00
210301	Гэрэл, цахилгаан	1,742,886.00	1,605,260.00
210302	Түлш, халаалт	4,524,639.00	4,491,921.00
210303	Цэвэр, бохир ус	974,473.00	562,042.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,270,313.00	25,026,930.00
210401	Бичиг хэрэг	8,375,025.00	7,199,450.00
210402	Тээвэр, шатахуун	2,793,000.00	1,953,660.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,796,800.00	1,557,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,090,000.00	1,015,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,215,488.00	13,231,220.00
2105	Нормативт зардал	55,870,025.00	50,256,418.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	55,131,625.00	45,587,718.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	738,400.00	4,668,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,038,250.00	18,523,570.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,435,050.00	1,109,800.00
210604	Урсгал засвар	14,603,200.00	17,113,770.00
2107	Томилолт, зочны зардал	1,097,600.00	5,267,400.00
210702	Дотоод албан томилолт	1,097,600.00	5,267,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,436,207.00	19,084,817.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,708,270.00	17,509,780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	89,100.00



210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,837.00	54,837.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	1,698,000.00	95,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,938,577.00	2,130,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	765,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,173,577.00	2,130,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,930,781.00	13,094,973.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,930,781.00	13,094,973.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,191,346.00	834,233.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,739,435.00	12,260,740.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(36,109,984.36)</u>	<u>(22,311,683.04)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	33,658,100.00	9,400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,658,100.00	9,400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,658,100.00	9,400,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,658,100.00	9,400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(33,658,100.00)</u>	<u>(9,400,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(69,768,084.36)	(31,711,683.04)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	153,891,546.32
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	153,891,546.32	122,179,863.28



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	182,225,247.40	48,868,428.75	480,411,605.99	711,505,282.14
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	182,225,247.40	48,868,428.75	480,411,605.99	711,505,282.14
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	182,225,247.40	48,868,428.75	480,411,605.99	711,505,282.14
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	182,225,247.40	48,868,428.75	480,411,605.99	711,505,282.14
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	182,225,247.40	48,868,428.75	480,411,605.99	711,505,282.14
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(12,400,851.44)	(12,400,851.44)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	182,225,247.40	48,868,428.75	468,010,754.55	699,104,430.70



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	908,638,029.01	786,458,165.73	-	86.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	908,638,029.01	786,458,165.73	-	86.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	895,543,056.01	773,363,192.73	-	86.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	562,563,259.00	562,563,259.00	-	-
210101	Үндсэн цалин	358,779,253.00	358,779,253.00	-	100
210102	Нэмэгдэл	63,312,806.00	63,312,806.00	-	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,166,000.00	58,166,000.00	-	-
210104	Урамшуулал	82,305,200.00	82,305,200.00	-	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,451,175.73	74,451,175.73	-	100
210201	Тэтгэврийн даатгал	54,768,119.03	54,768,119.03	-	100
210202	Тэтгэмжийн даатгал	3,172,968.12	3,172,968.12	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,497,384.07	1,497,384.07	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	1,385,435.58	1,385,435.58	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	13,627,268.93	13,627,268.93	-	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,659,223.00	6,659,223.00	-	100
210301	Гэрэл, цахилгаан	1,605,260.00	1,605,260.00	-	100
210302	Түлш, халаалт	4,491,921.00	4,491,921.00	-	100
210303	Цэвэр, бохир ус	562,042.00	562,042.00	-	100
2104	Хангамж, бараа материалын зардал	25,026,930.00	25,026,930.00	-	100
210401	Бичиг хэрэг	7,199,450.00	7,199,450.00	-	100
210402	Тээвэр, шатахуун	1,953,660.00	1,953,660.00	-	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,557,600.00	1,557,600.00	-	100
210404	Ном, хэвлэл	70,000.00	70,000.00	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,015,000.00	1,015,000.00	-	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,231,220.00	13,231,220.00	-	100
2105	Нормативт зардал	50,256,418.00	50,256,418.00	-	100
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,587,718.00	45,587,718.00	-	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,668,700.00	4,668,700.00	-	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,923,570.00	27,923,570.00	-	100
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00	300,000.00	-	-
210602	Тавилга	9,400,000.00	9,400,000.00	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,109,800.00	1,109,800.00	-	100
210604	Урсгал засвар	17,113,770.00	17,113,770.00	-	100

2107	Томилолт, зочны зардал	5,267,400.00	5,267,400.00	-	100
210702	Дотоод албан томилолт	5,267,400.00	5,267,400.00	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,084,817.00	19,084,817.00	-	100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,509,780.00	17,509,780.00	-	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00	-	100
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	89,100.00	-	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,837.00	54,837.00	-	100
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	-	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00	-	-
210807	Газрын төлбөр	95,100.00	95,100.00	-	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	124,310,263.28	2,130,400.00	-122,179,863.28	1.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,130,400.00	2,130,400.00	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,094,973.00	13,094,973.00	-	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,094,973.00	13,094,973.00	-	100
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	834,233.00	834,233.00	-	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,260,740.00	12,260,740.00	-	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	754,746,482.69	754,746,482.69	-	100
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	754,746,482.69	754,746,482.69	-	100
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	754,746,482.69	754,746,482.69	-	100
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	153,891,546.32	153,891,546.32	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		122,179,863.28	(122,179,863.28)	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	21.00	-	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	18.00	-	-
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан Уул аймгийн Дархан сумын "Гэрэлтэй" ерхийн эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг шуурхай чанартай хүргэснээр иргэдэд эрүүл зан үйлийг төлөвшүүлж, зонхилон тохиолдох өвчлөл, түүний нас баралтыг бууруулах" гэсэн эрхэм зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна. Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран ажиллах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар үр дүнг дээшлүүлэх, иргэдийн чирэгдлийг бууруулна.
- Удирдах ажилтны ёс зүйн харилцаа хамтын ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх
- Иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөлийг сайжруулах
- Хүүхэд хамгааллын чиглэл болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл Мэндийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 05 дугаар тогтоолоор хүн амын эрсдэлийн бүлгээр тооцсон, нэг иргэнд ногдох төлбөрийн хэмжээгээр санхүүжилтийг баталсан. Нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 80 хувийг шууд, 20 хувийг ЭМДҮЗ-ийн 2024 оны 6 дугаар тогтоолын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж гүйцэтгэлд суурилан олгодог. Тохиолдолд суурилсан дөрвөн тусламж үйлчилгээний санхүүжилтийг гүйцэтгэлд суурилан дараа сард нь олгодог.
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор 2024 оны 5 дугаар сараас эхлэн нэг иргэнээр тооцсон нэг сарын санхүүжилт 6 хувиар нэмэгдүүлж олгосон.
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тогтоолоор батлагдсан дундаж цалин хөлс тодорхойлох журмыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмыг шинэчлэн баталсныг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс
- Шинэчлэн найруулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор бараа, ажил, үйлчилгээ худалдан авах босго үнийг шинэчлэн тогтоосныг 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс
- Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталснаар 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс тус тус мөрдөж ажиллахаар заасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймаг Дархан сумын “Гэрэлтэй” өрхийн эрүүл мэндийн төв нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл/мөнгөн* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

НБББББ-ийг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байдлаар боловсруулан, хууль тогтоомжийн өөрчлөлтийг тухай бүр шинэчлэн баталж оруулсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймаг Дархан сумын “Гэрэлтэй” өрхийн эрүүл мэндийн төв нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,400.8 мянган төгрөгөөр буюу 1,7 хувиар буурсан байна. Энэ нь тайлант үеийн зардал нэмэгдсэнтэй холбоотой.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	153,891.6	122,179.8	(31,711.7)
Авлага	33,477.4	58,735.3	25,257.9
Бараа материал	104,147.6	83,878.1	(20,269.5)
Үндсэн хөрөнгө	419,988.7	434,311.2	14,322.5
Нийт хөрөнгө	711,505.3	699,104.4	(12,400.8)
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	711,505.3	699,104.4	(12,400.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	711,505.3	699,104.4	(12,400.8)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 31,711.7 мянган төгрөгөөр буурсан нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулсан зардлын санхүүжилтээ бүрэн авч чадаагүй авлага үүссэнтэй холбоотой.

Авлагын дансны үлдэгдэл 25,257.9 мянган төгрөгөөр өссөн нь 12 дугаар сарын гүйцэтгэлийн үр дүнгээр олгох 20 хувийн санхүүжилт болон 4 тусламж үйлчилгээний 11, 12 дугаар сарын санхүүжилтийг ЭМДЕГ санхүүжүүлэх эх үүсвэргүй болсонтой холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 83,878.1 мянган төгрөг болж 20,269.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 88,769.3 мянган төгрөгийн бараа материал, эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авч, ЭМЯ-наас 1,495.1 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, 17,970.9 мянган төгрөгийн Эм эмнэлгийн хэрэгсэл, 2,590.1 мянган төгрөгийн бусад хангамжийн материал нийт 22,056.1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан бөгөөд үйл ажиллагаанд 126,736,5

мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулж, 4,358.4 мянган төгрөгийг ашиглалтын хугацаа дууссан аж ахуйн эд зүйлсийг акталж устгасан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 434,311.2 мянган төгрөг болж 14,322.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2,050.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2,360.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 4,990.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө худалдан авч, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 75,384.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авсан, ЭМГ-аас 1,040.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандиваар хүлээн авч нийт 85,825.2 мянган төгрөгөөр өссөн. 12,640.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 988.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 13,638.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан тайлант онд элэгдлийн зардал 71,502.8 мянган төгрөг болсон нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 619,446.7 мянган төгрөг буюу нэг иргэнд ногдох нормативт зардлаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2024 онд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 80 хувийг урьдчилан олгож 20 хувийг гүйцэтгэлийн үр дүнг тооцож олгохоор төлөвлөсөн. 4 тусламж үйлчилгээний санхүүжилтийг гүйцэтгэлд суурилан авахаар төлөвлөсөн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний хөтөлбөрт зориулан 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр ЭМДС-аас 754,746.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн. Батлагдсан орон тоо 24 гүйцэтгэлээр 87.5 хувь буюу 21 хүн ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 786,458.2 мянган төгрөг 86,6 хувьтай байгаа нь тайлант онд ЭМД-ын сангийн санхүүжилтийн авлага 58,735.3 мянган төгрөг болон дансны үлдэгдэл 122,179.8 мянган төгрөг байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мян.төг/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71602 эмнэлгийн тусламж үйлчилгээ	1	80508 Төрийн бус байгууллагад төрөөс олгох дэмжлэг	908,638.0	786,458.2	122,179,8	86,6
	Нийт			908,638.0	786,458.2	122,179,8	86,6

Өрхийн эрүүл мэндийн төв нь нэг иргэнд ногдох норматив зардлаас худалдан авах ажиллагаагаар 10 нэр төрлийн бараа үйлчилгээнд 144,400.0 мянган төгрөг төлөвлөснөөс 102,034.2 мянган төгрөг буюу 70,6 хувь гүйцэтгэлтэй байна. Гүйцэтгэлээр 98,585.7 мянган төгрөгөөр шууд худалдан авалт хийж, 3,448.5 мянган төгрөгийн тендер зохион байгуулсан байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ болон бараа үйлчилгээний бусад зардалд 19,640.1 мянган төгрөг төлөвлөснөөс 100 хувь зарцуулсан.

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулаагүй байна

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн орлого байхгүй

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн “Гэрэлтэй” өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийн тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн “Гэрэлтэй” өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Шинжлэн магадлахуй ЭЗШ” аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 762,998.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 15,259.97 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага цалин болон нэмэгдэл урамшуулал, байр ашиглалттай холбоотой зардал, эм, эмнэлгийн хэрэгслийн зардал, тээвэр, шатахууны зардал, багаж, техник хэрэгслийн зардлаас нийт 122,179.9 мянган төгрөг хэмнэсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд улирал тутамд мэдээлэх 4 мэдээллийг 100 хувь байршуулж нийтэд ил болгосон. Мэдээллийн хэрэгжилт 100 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй. Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Тайлангийн 4.4.2 дахь хэсэгт дурдсан Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-